

**2023 OH**

## АГУУЛГА

1. ҮНДЭСЛЭЛ.....	2
2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ .....	3
3. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ.....	13
4. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ .....	21
5. ТОВЧ ДҮГНЭЛТ .....	22

## ХОЛБОГДОХ БУСАД

БҮДҮҮВЧ 1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ДАРААЛАЛ  
БҮДҮҮВЧ 2.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ДАРААЛАЛ  
БҮДҮҮВЧ 3.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ДАРААЛАЛ

ХАВСРАЛТ 1.ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖ

ХАВСРАЛТ 2.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

ХАВСРАЛТ 3.ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖ

ХАВСРАЛТ 4.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА


ХАВСРАЛТ 5.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

## НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг уг хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан доорх зардлын тооцоог хийв.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх шаардлага нь төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах, хуулийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолох болон холбогдох зардлын ачааллыг бууруулах боломж буй эсэхийг үнэлэх, санал боловсруулахад чиглэсэн.

Бүдүүвч 1.Хувилбар сонгох



Эх сурвалж: “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт зардлын тооцоог төрийн байгууллагын, хуулийн этгээдийн, болон иргэнд үүсэх гэсэн гурван төрлөөр тооцохоор тусгаж, холбогдон гарах зардлыг бууруулах боломж байгаа эсэхийг судлан, санал боловсруулсан.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг гол хууль болохын хувьд салбарын оролцогчдын эрх ашгийг тэгш хангаж, газар, өмч, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг нарийн зохицуулж, бусад хуультай нийцүүлэн, давхардал, хийдэл, зөрчилгүй байх зорилгоор боловсруулжээ.

Хуулийн төсөлд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд гарах зардлыг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан үндсэн оролцогч нэг бүрээр тооцоолон гаргав. Энэхүү тооцоололд дээрх аргачлалд тусгасны дагуу дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

- ✓ Төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэд энэхүү хуулиар хүлээсэн үүргийг оновчтой тодорхойлох;
- ✓ Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- ✓ Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд энэхүү хуульд баримтлахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмуудаас гадна ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаанд дараах зарчмуудыг баримтлахаар тусгасан. Үүнд:

- Ашигт малтмалыг сорчлон ашиглахгүй байх;
- Ил тод, нээлттэй, хариуцлагатай байх;
- Ашигт малтмал төрийн хяналтад, төлбөртэй байх;
- Ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлж үр ашигтайгаар ашиглах;
- Оролцогчдын хууль ёсны эрхийг хамгаалах;
- Хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.

Хуулийн төслийн зардлын тооцооллыг хийхдээ хуульд тусгагдсан чиг үүргийг гүйцэтгэхэд дээрхи зарчмуудыг алдагдуулахгүй байхыг зорьсон. Үндсэн оролцогчдод ногдох зардлыг одоогийн мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн зарим зүйл, заалтад нэмж туссан болон өөрчлөлт орсон тус бүрээр нь тооцон боловсруулсан.

Бодит тоон мэдээлэл болон харгалзах хугацааг авч ашиглах боломжгүй үед аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн тохиолдлын тоо, үйл ажиллагааны зардлыг адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, бусад хуулийн тооцоолол болон холбогдох газраас мэдээллийг авч ашиглалаа.

## ХОЁР.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ


Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргадаг.

Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шинээр үүсч буй чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцож гаргалаа.

Хуулийн төслийн 15 дугаар бүлэг буюу ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ бүлгийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт “Орон нутагт геологи, уул уурхайн салбарын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах чиг үүргийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгж хэрэгжүүлнэ”, мөн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв нь уул уурхайн тогтвортой хөгжлийн талаарх төрийн бодлого, стратеги, техник, технологи, инновацын хөгжил, ус, эрчим хүчний хэмнэлт, түүнчлэн геологи, уул уурхайн салбарын үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэх, олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн цогц судалгаа, дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана” гэж тус тус заасан байна.

Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд шинээр үүссэн Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг аргачлалын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолсон.

Бүдүүвч 2.Зардал тооцох үе шат



Эх сурвалж: “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох — тухайн хууль тогтоомжид хамаарах (1) төрийн байгууллага, (2) тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг

тодорхойлно. Энэхүү хуулийн төсөлд төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой өргөн хүрээтэй чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.


Энэ шатанд төрийн байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх төрийн байгууллагыг биш зөвхөн голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгохоор аргачлалд тусгасан. **Иймд хуулийн төсөлд шинээр тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг түүвэрлэн** тодорхойлж, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй гэж үзсэн. Үүнд:

- 1.Геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгж;
- 2.Геологи, уул уурхайн судалгааны төв гэсэн үндсэн 2 нэгжийг хамруулав.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох — хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон нэг жилд гүйцэтгэх тоог нэг ажилтанд шаардагдах нийт ажлын цагийн хамт тооцож гаргана. Ийнхүү тооцохдоо ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй төрийн байгууллагын ажил гүйцэтгэлийн хугацааг жишиг болгон багцлан тооцлоо.

Гүйцэтгэх үүрэг тус бүрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр шинээр бий болох нэгжид үүсэх зардлын тооцооллыг Хавсралт 1-ээр харуулав.

Бүдүүвч 3:Зардлын тооцоолол



Тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож

гаргасан.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх ажлын байрны тоог гаргасан.

Хүснэгт 1:Хүний нөөцийн хэрэгцээ

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг <sup>2</sup> /мин/	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв	2.880.000	96.000	30.0
Орон нутаг дахь 1 нэгж	475.000	96.000	4.9


Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

<sup>2</sup> Аргачлалын .... хэсэгт заасан жилд шаардагдах ажлын цагийг ашиглав.

Төрийн захиргааны байгууллагын хэмжигдэх боломжтой үүрэг тус бүрт тооцсон учраас энэхүү орон тоо үйл ажиллагаа өргөжихийн хирээр мөн энэ хуулийн хүрээнд бүрэн тусаагүй бусад дагалдах үүргийг гүйцэтгэхэд орон тоо нэмэх хэрэгцээг нөхцөлдүүлж болно. Тухайн чиг үүргийг шинээр ажилтан авч ажиллуулах болон одоо байгаа хүний нөөцийг ашиглан гүйцэтгэх эсэхийг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна. Дээрх тооцооллоор Судалгааны төвийн чиг үүргийг гүйцэтгэхэд 30, орон нутаг дахь нэгж чиг үүргээ гүйцэтгэхэд 4-5 орон тоотой буюу хүний нөөцийн хэрэгцээ байна гэсэн.

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** гарах зардлын тооцоог хийхэд дараах төрлийн зардлын мэдээлэлд тулгуурласан.

Бүдүүвч 4: Зардлын төрөл



Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тус байгууллагын 1 мэргэжилтэнд оногдох зардлыг хавсралт 3-д дурдсан судалгаанаас авна. Энэ зардал нь дунджаар 14.011.080,8 төгрөг байна.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гаргалаа.

Хүснэгт 2: Хүний нөөцийн хэрэгцээ


Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/	Цалингийн зардал	Хүнитий нөөцийн нийт зардал /төг/
Судалгаа, хөгжлийн төв	30	14.011.080,8	420.332.424,4
Орон нутаг дахь нэгж	4	14.011.080,8	56.044.4323,1
<b>Нийт хүний нөөцийн зардал</b>			<b>476,376,747.5</b>

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

Материаллаг зардалд хүснэгт 4 -т тусгасан зардлыг оруулан тооцов.

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** Энд нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, болон бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

Бүдүүвч 5: Нийт зардлын тооцоо



Эх сурвалж: “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”

Төсөвт үүсэх нийт ачаалал, зардлыг дараах байдлаар тооцож, гаргана.

Хүснэгт3: Төсөвт үүсэх зардал

№	Зардлын төрөл	Дүн /төгрөг/
1	Хүний нөөцийн дундаж зардал	476.376.745,5
2	Материаллаг дундаж зардал	40.230.747,0
3	Бусад зардал /Хуулийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зардал/	10.000.000,0
<b>Нийт зардал</b>		<b>526.607.492,5</b>

Эх сурвалж: “Ажиглалт” ХХК

**Тавдугаар үе шатны хүрээнд:** Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэнэ. Төрийн байгууллагын зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтоохыг зорьсон (Хүснэгт 1). Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилтээс төрийн байгууллагуудад хүлээгдэж буй үр, өгөөж нь үүсэх зардалтай харьцуулахад өндөр байгааг тооцооллоос харж болно.

Хүснэгт 4. Хялбарчлах боломж

№	Асуулга	Тайлбар
1	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэний эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийн тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.
2	Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа	Мэдээллийг холбогдох газрууд тайлангийн хугацаандаа бэлтгэж байгаа мэдээллийг ил тод, үр өгөөжтэй болгох нь хуулийн төслийн үндсэн зорилт учраас давтамжийг багасгах шаардлагагүй гэж үзлээ. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс



	эсэх	буурна гэж үзсэн.
3	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Ашигт малтмалын тухай хууль заасан мэдээллийг тайлагнах нь нэг талаас нийгмийн хэрэгцээ шаардлага боловч нөгөө талаас хуулийн этгээдийн болон тухайн хуулийн этгээдийн нууцтай холбоотой “эмзэг” мэдээллийг тайлагнах нь эрсдэл үүсгэх эсэхэд анхаарах шаардлагатай.
4	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэх бүрэн боломжтой. Иймд шинээр нэмэгдэл зардал үүсэх үндэслэл эрс буурсан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актын
5	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх	Мэдээллийг цахимаар хүргүүлэх бүрэн боломжтой. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллага, хуулийн этгээдүүд болон иргэд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс буурна гэж үзэж байна.
6	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах шаардлага байхгүй гэж үзсэн. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал буурна гэж үзэж байгаа учраас байгууллагын тоог бууруулах бус харин мэдээллийн агуулгын баяжуулах шаардлагатай.
7	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх	Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан ил тод байдлыг улам нэмэгдүүлэх. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой бүрэн үүссэн. Дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн системийг үе шаттайгаар нэвтрүүлснээр холбогдон гаран зардал оролцогч бүх талуудад эрс буурна гэж үзэж байна.

Эх сурвалж: “Ажиглалт” ХХК

## Дүгнэлт

Тус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны орлого болон бусад судалгаа шинжилгээ, байгаль орчны үнэлгээ зэрэг үйл ажиллагааны орлогыг жил бүр улсын болон орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлдэг.

Иймд төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн **10 хувиас** доошгүй хувийг шинээр бий болгох нэгжийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулахад зориулалттайгаар тусгахад улсын төсөвт шинээр зардал бий болохгүй бөгөөд зөвхөн төсвийн хуваарилалт төлөвлөлтөд тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах шаардлага үүсэхээр байна.

## ГУРАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ


Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох аргачлалд тусгаснаар хуулийн этгээдийн зардал нь тухайн хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулж байгаа мөнгөн зардал байхаар тусгасан.

Аргачлалын 2.3 дахь хэсэгт гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо, баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг заасан. Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмждэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүдийг хамааруулж ойлгоно.

Тухайлбал, аливаа нэг хуулийн этгээдээс тухайн үүргийг гүйцэтгэхэд хэдий хэр цаг хугацаа зарцуулах, шинээр бий болгох үүрэгтэй ойролцоо өөр ямар үүрэг байна, түүнд хэдий хэр хугацаа зарцуулдаг вэ? гэх мэт судалгаа авсан.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг доорхи 6 алхам буюу үе шатаар тооцож гаргалаа. Нийт зардлыг хүснэгт 4 тодорхойлж харуулжээ.

Бүдүүвч 6. Хуулийн этгээдэд үүсэх зардал



Эх сурвалж: “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдүүдийн хүлээх:

- Yүрэг болгосон эрх зүйн заалт нэг бүрийг тодорхойлох,
- Yүргийн агуулга нэг бүрийг тодорхойлох;
- Yүрэг гүйцэтгэх хуулийн этгээд нэг бүрийг тодорхойлж гаргасан.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт ашигт малтмалын хайх, ашиглах, баяжуулах 3 төрлийн тусгай зөвшөөрөл байх ба 7.5 дахь хэсэгт “нэг тусгай зөвшөөрлийг зөвхөн 1 хуулийн этгээдэд олгоно” гэж тусгасан байна.

Хүснэгт 5: Үүрэг болгосон заалт

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг
14.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар дараах байдлаар олгоно.	6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төрийн нийтийн өмчийг хайх, ашиглах эрхийг зөвхөн энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд хугацаатайгаар олгоно.	16.2.2.хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн төлөх;  16.2.9.хайгуулын ажлын анхдагч тоон өгөгдлийг хайгуулын ажлын болон үр дүнгийн тайлангийн хамт ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
20.7.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг техник, эдийн засгийн үндэслэлтэй уялдуулан 10-20 жилийн хугацаагаар олгоно.		22.2.3.ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн төлөх;  20.8.Энэ хуулийн 20.7-д зааснаас дээш хугацаагаар ордыг ашиглах тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг ордын нөөцөд үндэслэн 10 жилээр хоёр удаа сунгаж болно
26.5.Энэ хуулийн 26.4-т заасан шаардлага хангасан тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.		26.6.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээгээр төлнө.  27.2.1.үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх;
18.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын тусгай зөвшөөрлийн эхний гурван жилийн хугацаанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэнэ.		18.4.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгогдсон тухайн талбайн хайгуулын ажлыг жил бүр гектар тутамд дараах хэмжээнээс багагүй зардлаар хийж гүйцэтгэнэ: 18.4.1.тусгай зөвшөөрлийн хоёроос гурав дахь жилд 3500 төгрөг; 18.4.2.тусгай зөвшөөрлийн дөрвөөс зургаа дахь жилд 7000 төгрөг; 18.4.3.тусгай зөвшөөрлийн долоогоос ес дэх жилд 35000 төгрөг; 18.4.4.тусгай зөвшөөрлийн арваас арван хоёр дахь жилд 70000 төгрөг

Эх сурвалж:"Ажиглалт" ХХК

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** Гүйцэтгэх үүрэг тус бүрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр нэг хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлыг тооцов. Түүнчлэн, хуулийн этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хэмжих боломжтой ажлыг хамааруулдаг. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн хувьд хууль, тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан дараах 2 төрлийн мөнгөн зардлыг тооцно:

1. Үүргийг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа;
2. Ажилтан олгох цалингийн зардал.

Хүснэгт 6: Зарцуулах хугацаа

Үүрэг	Агуулга	Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	
Тусгай зөвшөөрөлтэй байх	Шинээр авах  /өргөдөл, гэрээ, сургалтын хөтөлбөр, аудитын тайлан, баталгаа/	Өргөдөл бичих	30	
		Аж ахуйн нэгжийн холбогдох баримт бичгийг нотариатаар баталгаажуулах	60	
		гэрээний төсөл гаргах	60	
		Бусад баримт	60	
		санхүүгийн аудитын тайланг хуулбарлах	60	
		Банкны баталгаа гаргуулах	30	
	<b>Нийт хугацаа</b>			<b>300</b>
	Хугацааг сунгах /өргөдөл, гэрээ/	Өргөдөл гаргах	60	
		Тайлан хавсаргах	60	
	<b>Нийт хугацаа</b>			<b>120</b>
Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэх	Гэрээ байгуулах	Стандарт ажил хийгдэнэ	1440	
	Гэрээний хяналт	Захиалагчийн хяналт хэрэгжүүлнэ	7200	
	Тайлан хүлээн авах	Стандарт ажил хийгдэнэ	1400	
	<b>Нийт хугацаа</b>			<b>10040</b>

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

**Ажлын хөлсийг** тооцож гаргахдаа эхлээд ажилтанд олгох сарын үндсэн цалин, сард ажиллах хугацааг тодорхойлж гаргана. Ингээд үндсэн цалингаа ажиллах хугацаанд хувааж тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг гаргана.

Ажилтаны сарын үндсэн цалин дундажаар 1,0 сая гэж үзэхэд:

$$\text{АЖЛЫН ХӨЛС} = \text{ҮНДСЭН ЦАЛИН} \div \text{АЖИЛЛАХ ХУГАЦАА}$$

Тайлбар: Нэг сараар тооцно

Хүснэгт 7: Ажлын хөлсний зардал

№	Үүрэг	Ажлын хөлс	Үндсэн цалин	Ажиллах хугацаа
1	Зөвшөөрөл авах	3.3₮	1.0 сая	300
2	Хугацаа сунгах	8.3₮	1.0 сая	120

3	Үнэлгээний тайлан гаргах	99.6₮	1.0 сая	10040
---	--------------------------	-------	---------	-------

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** Зардлын тооцоог хүний нөөцийн болон бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлов. Хуулийн этгээд хуанлийн 1 жилийн хугацаанд тухайн үүргийг хэдэн удаа давтан хэрэгжүүлэхээс хамаарч, тохиолдол буюу давталтын тоог гаргана.

Тусгай зөвшөөрөл авах үүргийн тухайд жилд олгогдож буй тусгай зөвшөөрлийн тоогоор тохиолдлын тоог гаргана. Тохиолдлын тоог сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлтээр дундажлан гаргав.

Хүснэгт 8: Тохиолдлын статистик

№	Тохиолдол	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Тохиолдлын тоо
1	<b>Шинээр олгосон тусгай зөвшөөрөл</b>	<b>85</b>	<b>130</b>	<b>90</b>	<b>163</b>	<b>93</b>	<b>117</b>
	Ашиглалт	61	59	55	54	36	41
	Хайгуул	24	71	35	109	57	76
2	<b>Сунгалт хийгдсэн</b>	<b>566</b>	<b>300</b>	<b>68</b>	<b>246</b>	<b>291</b>	<b>294</b>
	Ашиглалт	0	0	0	0	0	
	Хайгуул	566	300	68	246	291	294
3	<b>Нарийвчилсан үнэлгээ тайлан</b>	<b>281</b>	<b>337</b>	<b>259</b>	<b>260</b>	<b>363</b>	<b>299</b>
	Байгаль орчны нөлөөллийн	188	225	184	172	209	195
	Техник эдийн засгийн үзүүлэлт	93	112	75	88	154	104

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудас

Дээрх статистик мэдээллээс харахад жил дунджаар 117 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 294 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, нарийвчилсан үнэлгээний тайлан 299 хийгддэг байна.

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** нийт зардлын дүнг тооцох үе шатанд зардлын нийт дүнг тооцож гаргадаг. Ингэж тооцохдоо тухайн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж гаргасан. Хуулийн төсөлд ажил, үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан хуулийн этгээдүүдийн зардлыг тооцоолоход **299.4 сая** төгрөгийн зардал гарахаар тооцоо гарч байна.

**НИЙТ ЗАРДАЛ = ЗАРДАЛ × ТООН ҮЗҮҮЛЭЛТ**

Өөрөөр хэлбэл өмнөх шатанд тооцож гаргасан үйл ажиллагаа нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж, нийт зардлын дүн гарна.

Хүснэгт 9: Зардлын тооцоо

№	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Тохиодлын тоо	Үндсэн зардал	Нийт зардал
1	Шинээр тусгай зөвшөөрөл авах	300 мин	117	3.3₮	115.830 ₮
2	Хугацаа сунгах	120 мин	294	8.3₮	292.824₮
3	Үнэлгээний тайлан	10040 мин	299	99.6₮	298.995.216₮
<b>Нийт зардал</b>					<b>299.403.870</b>

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

**Тавдугаар үе шатны хүрээнд:** Энэ шатанд хялбарчлах боломжийг шалгадаг бөгөөд өмнөх үе шатанд тодорхойлсон хэмжигдэх боломжтой үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг дараах асуулгаар тодруулж гүйцэтгэлээ. Аргачлалын 2.7 дахь хэсэгт тусгасан хялбарчлах боломжийг шалгах үе шатыг дараах хүснэгт 10 харуулсан.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг бууруулах боломж байгаа эсэхийг шалгасны дараа бага зардлаар зорилгодоо хүрэх үр ашигтай хувилбарыг сонгоно.

Бүдүүвч 7: Шалгах асуулт



Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

Хүснэгт 10: Зардлын тооцоо

№	Асуулга	Тайлбар
1	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэний эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийн тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.
2	Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх	Мэдээллийг холбогдох газрууд тайлангийн хугацаандаа бэлтгэжбайгаа мэдээллийг ил тод, үр өгөөжтэй болгох нь хуулийн төслийн үндсэн зорилт учраас давтамжийг багасгах шаардлагагүй гэж үзлээ. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс буурна гэж үзсэн.
3	Мэдээллийн агуулгыг багасгах боломжбайгаа эсэх	Ашигт малтмалын тухай хууль заасан мэдээллийг тайлагнах нь нэг талаас нийгмийн хэрэгцээ шаардлага боловч нөгөө талаас хуулийн этгээдийн болон тухайн хуулийн этгээдийн нууцтай холбоотой “эмзэг” мэдээллийг тайлагнах нь эрсдэл үүсгэх эсэхэд анхаарах шаардлагатай.
4	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болохэсэх	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэх бүрэн боломжтой. Иймд шинээр нэмэгдэл зардал үүсэх үндэслэл эрс буурсан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааны өгөөж энэхүү шинэчилсэн найруулгын хүрээнд шинэ түвшинд хүрч, нэмэгдэнэ гэж үзсэн.
5	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх	Мэдээллийг цахимаар хүргүүлэх бүрэн боломжтой. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллага, хуулийн этгээдүүд болон иргэд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс буурна гэж үзэж байна.
6	Мэдээллийг хүргүүлэх байгууллагынтоог багасгах боломжтой эсэх	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах шаардлага байхгүй гэж үзсэн. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал буурна гэж үзэж байгаа учраас байгууллагын тоог бууруулах бус харин мэдээллийн агуулгын баяжуулах шаардлагатай.
7	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх	Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан ил тод байдлыг улам нэмэгдүүлэх. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой бүрэн үүссэн. Дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн системийг үе шаттайгаар нэвтрүүлснээр холбогдон гаран зардал оролцогч бүх талуудад эрс буурна гэж үзэж байна.

Эх сурвалж: “Ажиглалт” ХХК

### Дүгнэлт

Хүснэгт 9 дээрх зардлын тооцооллоос харахад жилд дунджаар 240 орчим хуулийн этгээд, байгууллага хуульд заасан тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд 299.4 сая төгрөгийн зардал гаргахаар байна. Энэхүү зардлыг 1 хуулийн этгээдэд ноогдуулахад тухайн чиг үүргийг үүргийг гүйцэтгэхэд 1.2 сая төгрөгийн зардал гаргахаар тооцоологдож байна.

Түүнчлэн хуулийн төсөлд тусгаснаар тусгай зөвшөөрлийг шинээр авахад 10

жилээр олгох ба сунгалтыг 10-20 жилээр хийгдэх тул энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардал нь 10 жил тутамд 1 удаа гарна.

Иймд тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, ашиг орлогод ачаалал үүсэхээргүй байна гэж дүгнэж байна.

---


<sup>9</sup> Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын Хүснэгт 3.



## 4. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцох ажлыг доорхи 5 үе шатаар хийнэ:

Бүдүүвч 8: Иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцох үе шат



Эх сурвалж: “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”

### Анхаарах зүйл:


Иргэний хувьд хууль тогтоомжид тусгагдсан үүргийг гүйцэтгэхдээ холбогдуулан гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацааг /ачаалал/ тооцно.

Үе шат бүрт хийгдэх ажилбарыг нэг бүрчлэн тайлбарлахад:

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Иргэний гүйцэтгэх үүргийг тогтооно.

Иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлохын тулд дараах алхамыг зайлшгүй хийнэ.

Бүдүүвч 8: Иргэний гүйцэтгэх үүрэг



-Хууль тогтоомжид тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн тодорхойлно;  
-Тодорхойлсон үүргийн агуулга нэг бүрийг тодорхойлно.

Эх сурвалж: “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”


Хуулийн төслийн 73 дугаар зүйлийн 73.4 дэх хэсэгт Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын

зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** Цаг хугацааны зарцуулалт болон зардлыг тооцно.

Иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцохдоо дараах алхмыг гүйцэтгэнэ:

Бүдүүвч 9: Иргэнд үүсэх зардал, ачаалал тооцох алхам



- Түүнчлэн үүргийг хэрэгжүүлэхэд гарах мөнгөн зардлыг бас тооцно;
- Тухайн үүргийн дагуу хичээн төрлийн үйл ажиллагаа хийх ёстойг тодорхойлж агуулгаар нь нэгтгэнэ;
- Үүрэг бүрийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг тогтоох нь харилцан адилгүй боловч тухайн хуулийн үйлчлэлд хамаарах иргэдийн хувьд амьдарч буй газар нутаг, нийгмийн байдал зэргээс хамааран цаг хугацааг баримжаалан тооцно.

Хүснэгт 11: Иргэний гүйцэтгэх үйл ажиллагааны хугацаа

№	Гүйцэтгэх үүрэг	Агуулга	Зарцуулах хугацаа
1	... мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх	Холбогдох мэдээллийг бүрдүүлэх геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд өгөх	60 мин 30 мин

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

Иргэний гүйцэтгэх үйл ажиллагааны **хугацааг** тогтоохдоо тогтсон стандарт байдаг бол түүнийг ашиглах ба байхгүй тохиолдолд баримжаалж тогтооно.

**Мөнгөн зардлыг** тооцохдоо тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөн зардал буюу бодит, тогтсон зардлыг тооцно. Үүнд: мэдээллийг холбогдох газарт хүргүүлэхэд гарах бичиг хэрэг, шуудангийн зардал, баримт бичгийг нотариатаар баталгаажуулахыг тухайлан шаардсан тохиолдолд нотариатын зардлыг оруулна.

## Гуравдугаар үе шатны хүрээнд: Тоон үзүүлэлтийг тооцох

Энэ үе шатанд иргэний гүйцэтгэх үүргийг тухайн харилцаанд оролцогч хичнээн иргэн жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн нэг жилээр тооцож гаргана.

Бүдүүвч 10: Иргэнд үүсэх тоон үзүүлэлтийг тооцох



## Гуравдугаар үе шатны хүрээнд: Нийт дүнг тооцож, гаргах

### Дүгнэлт

Хуулийн төслийн 73 дугаар зүйлийн 73.4 дэх хэсэгт Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.

Иргэн гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрөөр санхүүжилт хийгдсэн ажлын хүрээнд үүссэн баримт материалыг архивын нэгж болгон мэдээллийн санд төвлөрүүлж байна тиймээс иргэнд захиргааны зардал үүсэхээргүй тооцоологдож байна.

--oOo--

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА**

Хүснэгт .

Төрийн байгууллага	Хуулийн төсөлд хамаарах зүйл, заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Тохиолдол тоогоор /өдрөөр жилд хийх давтамж/	Зарцуулах хугацаа /минут/	Нийт зарцуулах хугацаа /минут/
<b>НЭГ.ОРОН НУТАГ ДАХЬ НЭГЖ</b>					
<b>1.1.Аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан 1 нэгж</b>	Хуулийн төслийн 66 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (66.1 - 66.2)	Орон нутагт геологи, уул уурхайн салбарын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	100	1150	115000
		Сурталчлан таниулах,	50	1200	60000
		Хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, чиг үүргийг	100	2000	200000
		Төрийн болон нутгийн захиргааны байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах	100	800	80000
		Бусад	40	500	20000
<b>Нийт шаардагдах хугацаа</b>					<b>475.000</b>
<b>ХОЁР. УУЛ УУРХАЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ</b>					
<b>Уул уурхайн судалгаа хөгжлийн төв</b>	Хуулийн төслийн 69 дугаар зүйлд заасан чиг	69.2.1.салбарын бодлогын суурь судалгаа, олон улсын болон дотоодын зах зээлийн хэтийн төлөв, хөрөнгө оруулалт, татварын орчны судалгаа, төсөл, хөтөлбөрийн хөгжүүлэлт, дэд бүтцийн судалгаа хийх, үнэлэлт дүгнэлт өгөх;	250	1480	370 000
		69.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, техник ашиглалт, аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээний холбогдолтой олон улсын болон дотоодын эрх зүйн актуудын хэрэгжилтийн статистик судалгаанд тулгуурлан салбарын дүрэм, стандарт, норм нормчлолын бичиг баримт боловсруулах, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;	250	480	120 000
		69.2.3.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд мэргэжлийн байгууллагыг төлөөлж геологи, судалгааны асуудал хариуцсан болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын архив, сан хөмрөг, мэдээллийн сангийн мэдээллийн нийцэл, холбогдох	250	2000	500 000

үүргүүдийг хэрэгжүүлэх (69.2.1 - 69.2.8)	харилцааг зохицуулсан хэм хэмжээний актууд болон хууль эрх зүйн актуудын шаардлагыг хангасан байдалд дүгнэлт гаргах шинжээчээр ажиллах, өөрийн гаргасан дүгнэлтэндээ хариуцлага хүлээх;			
	69.2.4.техник, технологийн түвшний үнэлгээ хийх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын захиалгаар төслийн хэрэгжилтэд энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан технологийн аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх;	200	3000	600 000
	69.2.5.уул уурхайн салбарын мэргэжилтэй боловсон хүчний судалгаа, мэргэжлийн боловсрол дээшлүүлэх, тэсэлгээчин, аврагч, технологийн аудитор, хөдөлмөрийн аюулгүй байдлын зэрэг тусгай чиг үүрэг бүхий үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэн бэлтгэх, зөвлөх болон мэргэшсэн зэрэг олгох, мэргэшүүлэх сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэрээний үндсэн дээр зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;	1000	1200	1200 000
	69.2.6.технологийн аудит хийх байгууллагад энэ хуулийн 10.1.17-д заасан журмын дагуу, маркшейдерын ажил, үйлчилгээ эрхлэх байгууллагад энэ хуулийн 10.1.18-д заасан журмын дагуу, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах байгууллагад энэ хуулийн 10.1.38-д заасан журмын дагуу тус тус эрх олгох, сунгах, цуцлах талаарх саналыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх;	300	100	30000
	69.2.7.тусгай зөвшөөрлийн хилийн маргаан, шүүхийн болон цагдаагийн байгууллагаас гаргасан хүсэлтийг үндэслэн төрийг төлөөлөн шинжээчээр ажиллах, маркшейдерын хэмжилт хийх, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргах ба өөрийн гаргасан дүгнэлтэд хариуцлага хүлээх;	300	100	30 000
	69.2.8.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд хийсэн зохиогчийн хяналтын гэрээт ажилд экспертын баталгаажуулалт хийх.	300	100	30 000
<b>Нийт шаардагдах хугацаа 2880 000 минут</b>				

<sup>8</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ АГЕНТЛАГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ДУНДАЖ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Албан тушаал	Албан тушаалтны тоо	Цалингийн зэрэглэл <sup>3</sup>	Үндсэн цалин	Нэмэгдлийн хувь	Нэмэгдлийн мөнгөн дүн	Алба хаасны хугацаа	Хоол унаа /өдөр/	НДШ	1 сарын цалин	12 сарын цалин	Нийт
<b>Нэг.Орон нутаг дахь нэгж</b>												
1	Дарга	1	Т3 - 8	1392,576.0	30	417,772.8	139,257.6	20,000.0	278,515.0	2,248,121.4	26,977,456.8	26,977,456.8
2	Мэргэжилтэн	3	Т3 - 8	1283,967.0	30	385,190.1	128,396.7	20,000.0	256,793.0	2,074,346.8	24,892,161.0	74,676,484.8
<b>Хоёр.Судалгаа, хөгжлийн төв</b>												
1	Дарга	1	Т3 - 5	1045,653.0	30	313,695.9	104,565.3	20,000.0	209,130.0	1,693,044.2	20,316,530.4	20,316,530.4
2	Ахлах мэргэжилтэн	10	Т3 - 6	1002,648.0	30	300,794.4	100,264.8	20,000.0	200,529.0	1,624,236.2	19,490,834.4	194,908,344.0
3	Мэргэжилтэн	18	Т3 - 7	924,456.0	30	277,336.0	92,445.6	20,000.0	184,891.0	1,499,128.6	17,989,543.2	143,916,346.7
4	Үйлчлэгч	1	ТҮ - 6	799,041.0	30	239,712.3	79,904.1	20,000.0	159,808.0	1,298,465.4	15,581,584.8	15,581,584.8
	<b>Нийт</b>	<b>34</b>		<b>6,448,341.0</b>		<b>1,934,501.5</b>	<b>644,834.1</b>	<b>1,200,000</b>	<b>1,289,666.0</b>	<b>10,437,342.6</b>	<b>100,380,842.6</b>	<b>476,376,747.5</b>

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 488-р тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай"

## МАТЕРИАЛЛАГ ЗАРДЛЫН ДУНДАЖ ТООЦОО

Ном хэвлэл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Хэвлэл захиалга	4	160,000.0	640,000.0
Номны үнэ	25	65,000.0	1,625,000.0
Хэвлэлээр зарлал мэдээлэл	5	250,000.0	1,250,000.0
<b>ДҮН</b>			<b>3,515,000.0</b>
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Цэвэрлэгээний материал	12сар	200,000.0	2,400,000.0
Гэрэл цахилгаан, сантехник, бусад эд хогшлын холбогдолтой сэлбэг хэрэгсэл,гэрлийн шил, залгуур г.м	4 ул	450,000.0	1,800,000.0
Цай, кофе, сахар, ус	12	100,000.0	1,200,000.0
<b>ДҮН</b>			<b>3,960,000.0</b>
Урсгал засвар	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Компьютер, тоног төхөөрөмжийн засвар	35	12,000.0	456,000.0
Бусад	1	2000000	2000000
<b>ДҮН</b>			<b>2,456,000.0</b>
Нэг удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшил	Хүний тоо	Нэгжийн үнэ	Нийт зардал
Шагнал урамшуулал	34	4,174,936.0	16,699,747.0
Шинээр гэр бүл болох	3	700,000.0	2,100,000.0
Ажилтанд гэнэтийн уй гашуу тохиолдоход /дотоод журмын дагуу ажилтны гэр бүлийн гишүүн хүндээр өвдөх, нас барахад/	3	500,000.0	1,500,000.0
<b>ДҮН</b>			<b>20,299,747.0</b>
Төлбөр хураамж бусад	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Аудитын төлбөр	1	10,000,000.0	10,000,000.0
<b>ДҮН</b>			<b>10,000,000.0</b>
<b>Нийт</b>			<b>40,230,747.0</b>

## ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

	Хуулийн төсөлд хамаарах зүйл, заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Тохиолдол тоогоор /өдрөөр жилд хийх давтамж/	Зарцуулах хугацаа /минут/	Нийт зарцуулах хугацаа /минут/
Хуулийн этгээд	14.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар дараах байдлаар олгоно. 20.7.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг техник, эдийн засгийн үндэслэлтэй уялдуулан 10-20 жилийн хугацаагаар олгоно	Шинээр тусгай зөвшөөрөл авах	300 мин	117	3.3₮
	20.7.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг техник, эдийн засгийн үндэслэлтэй уялдуулан 10-20 жилийн хугацаагаар олгоно.	Хугацаа сунгах	120 мин	294	8.3₮
	18.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын тусгай зөвшөөрлийн эхний гурван жилийн хугацаанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэнэ.	Үнэлгээний тайлан	10040 мин	299	99.6₮
<b>НИЙТ ЗАРДАЛ 299.403.870 төгрөг</b>					



## ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Иргэн	Хуулийн төсөлд хамаарах зүйл, заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Тохиолдол тоогоор /өдрөөр жилд хийх давтамж/	Зарцуула ххугацаа /минут/	Нийт зарцуулах хугацаа /минут/
<b>ИРГЭН</b>					
<b>Иргэн (Хэрэглэгч)</b>	Хуулийн төслийн 73 дугаар зүйлд заасанчиг үүргүүдийг хэрэгжүүлэх (73.4)	73.4.Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.	Тоон хэмжүүрээр боломжгүй үйл ажиллагаанд хамаарна. Холбогдох зардал үүсэхгүй.		хэмжигдэх зардал

----- о О о -----